



МАЛ АЖ АХУЙ, 2021 оны эхний 2 сард

ᠮᠠᠯ ᠠᠵᠤ ᠠᠬᠤᠢ

ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр



ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, БҮСЭЭР, мянган толгой



2/2021

Тархаасан: 2021 оны 3 дугаар сарын 15



Улсын хэмжээнд 540.4 мянган мал хорогдсон байна

Том малын зүй бус хорогдол 2021 оны эхний 2 сард улсын хэмжээнд 540.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 366.4 (3.1 дахин их) мянгаар нэмэгдсэн байна. Харин 2021 оны 2 дугаар сард 243.9 мянган толгой мал хорогдсон нь эхний 2 сард хорогдсон малын 45.1 хувийг эзэлж байна.


Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, ямаа 298.6 мянга, хонь 159.6 мянга, үхэр 52.9 мянга, адуу 26.0 мянгаар, тэмээ 3.3 мянган толгой хорогдсон байна. Нийт хорогдсон малын 55.3 хувийг ямаа, 29.5 хувийг хонь эзэлж байна.

Хүснэгт 1. Хорогдсон том мал, төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, мянган толгой

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Дүн	709.6	165.9	174.0	540.4	1.07	0.25	0.25	0.81
Адуу	35.3	7.3	8.8	26.0	0.89	0.18	0.21	0.55
Үхэр	52.9	15.0	13.9	52.9	1.20	0.34	0.29	1.29
Тэмээ	0.3	0.1	0.1	3.3	0.08	0.03	0.02	0.69
Хонь	213.4	59.2	80.1	159.6	0.71	0.19	0.25	0.53
Ямаа	407.7	84.3	71.1	298.6	1.49	0.31	0.24	1.08

Хорогдлыг аймгаар нь авч үзэхэд 2021 оны эхний 2 сард Баянхонгор аймагт 259.1 (47.9 хувь) мянга, Өвөрхангай аймагт 54.5 (10.1 хувь) мянга, Говь-Алтай аймагт 41.6 (7.7 хувь) мянган толгой мал хорогдсон байна. Дээрх аймгууд нь нийт хорогдлын 65.7 хувийг эзэлж байна.


Зураг 1. Том малын зүй бус хорогдол, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, мянган толгой



Улсын хэмжээнд 2020 оны эцэст тоологдсон 29.7 сая эх малын 122.6 мянга (0.4%) нь 2021 оны эхний 2 сард хорогдсон байна. Архангай, Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор аймгуудад хээлтэгч мал 7.1-75.2 мянган толгойгоор хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 79.8 хувийг эзэлж байна. Харин хээлтүүлэгч малын хорогдол 7.7 мянга болж, ухна 4.7 мянга, хуц 2.0 мянга, бух 0.7 мянга, азарга 0.3 мянга, ат 10 толгойгоор тус тус хорогдсон байна.

Улсын хэмжээнд өвчнөөр хорогдсон мал 2021 оны эхний 2 сард 1.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.2 (12.7 хувь) мянгаар буурсан байна.

Зураг 2. Өвчнөөр хорогдсон мал, төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Хорогдсон нийт том малын 0.2 хувь нь өвчнөөр, 6.8 хувь нь аюулт үзэгдлээр, 93.0 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг шалтгааны улмаас хорогдсон байна.

Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дэх нас гүйцсэн эм малыг хамруулна.

Эх үүсвэр: ҮСХ, Том малын зүй бус хорогдлын мэдээ

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>



Дараагийн мэдээ тархах хуваарь: 2021 оны 4 дүгээр сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
 дарга Э.Эрдэнэсан
 Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын
 статистикч Э.Болормаа
 Утас : (976-51)-261565